

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2011 оны 9 дүгээр сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2011 оны 9 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	/тоогоор/			
		2011-8 сар	Нэмэгдсэн	Хасагдсан	2011-9 сар
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	150	2 ¹		152
3	Даатгалын төлөөлөгч	2060	20 ²		2080
4	Даатгалын зуучлагч	8			8
5	Даатгалын хохирол үнэлэгч	8			8
6	Актуарч	12			12
7	Бусад		3 ³		

Тайлант үед даатгалын компани, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны даргын 2011 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 146 дугаар тушаалаар “Ард даатгал” ХХК-д Улаанбаатар хотын Сүхбаатар, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт даатгалын компанийн 2 салбар нээн ажиллуулахыг зөвшөөрсөн;

²Хорооны даргын 2011 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 133 дугаар тушаалаар “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 20 төлөөлөгчид даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон;

³Хорооны 2011 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 251 дүгээр тогтоолоор “Мандал женерал даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээгээ нэмэгдүүлэхийг, 252 дугаар тогтоолоор “Аме” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг тус тус зөвшөөрч, 253 дугаар тогтоолоор “Миг даатгал” ХХК-ийн 7 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2011 оны 9 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны 9 дүгээр сарынхтай харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2010-9 сар	2011-9 сар
1	Даатгалын нийт хураамж	1,998,400,879.8	4,447,558,112.2
2	Олгосон нийт нөхөн төлбөр	439,695,889.7	1,025,058,527.0
3	Давхар даатгалд төлсөн хураамж	669,422,827.3	1,665,833,867.3
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	10,997	9,713
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	69,534,624,329.4	77,255,400,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	21,389,100.0	62,511,968.5

2011 оны 9 дүгээр сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 2,449.5 сая төгрөгөөр өсч, урд сарынхаас 188.0 сая төгрөгөөр буурч, олгосон даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 585.4 сая төгрөгөөр, өмнөх сарынхаас 196.4 сая төгрөгөөр тус тус өссөн, давхар даатгалд төлсөн хураамж өмнөх оны мөн үеийнхээс 996.4 сая төгрөгөөр өсч, өмнөх сарынхаас 53.9 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Даатгалын компаниудын олсон нийт даатгалын хураамж болон олгосон даатгалын нөхөн төлбөрийн өсөлт, бууралтыг 2011 оны эхний 9 сарын байдлаар дараах графикаар үзүүлье /сая төгрөгөөр/:




Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	2010-9 сар	2011-9 сар
1	Даатгалын нийт хураамж	9,258,294.3	37,642,732.8
2	Олгосон нийт нөхөн төлбөр	10,714,865.7	13,353,197.1
3	Давхар даатгалд төлсөн хураамж	6,820,928.0	
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	4	58

	Үүнээс:-Хувь хүний хугацаат даатгалд	2	8
	-Байгууллагын хугацаат даатгалд	1	1
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		
	-Эмнэлгийн мөнгөний даатгалд	1	32
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд		14
	-Тэтгэврийн даатгалд		3
	-Орон сууцны даатгалд		
	-Хуримтлалын даатгалд		
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	5,000,000.0	20,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	6,165,445.7	6,000,000.0

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2011 оны 9 дүгээр сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулбал даатгалын хураамжийн орлого 28.4 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 2.6 сая төгрөгөөр тус тус өсч, өмнөх сарынхтай харьцуулахад даатгалын хураамжийн орлого 9.2 сая төгрөгөөр өссөн, даатгалын нөхөн төлбөр 4.9 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн төвлөрүүлсэн даатгалын хураамж болон олгосон даатгалын нөхөн төлбөрийн өсөлт, бууралтыг 2011 оны эхний 9 сарын байдлаар графикаар үзүүлье /сая төгрөгөөр/:



Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-7 сар	2011-8 сар	2011-9 сар
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	30,521,004.9	47,914,877.1	32,272,425.1

2	Даатгалын зуучлагчийн орлого	20,426,011.2	19,439,897.3	13,427,330.0
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	55	46	58
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	248,000,000,000.0	1,980,957,007.0	3,855,417,989.0

2011 оны 9 дүгээр сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 58 даатгалын гэрээг даатгагчдад зуучлан 13.4 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

		/төгрөгөөр/		
№	Үзүүлэлт	2011-7 сар	2011-8 сар	2011-9 сар
1	Даатгалын хохирол үнэлсэний орлого	3,192,818.2	3,824,318.2	3,727,000.0
2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	111	193	217
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	80,258,000.0	9,002,000.0	16,260,000.0

2011 оны 9 дүгээр сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 217 даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж 3.7 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.